



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/507

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.11, 14.1.14 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг нэгдүгээр, хяналт шалгалтын тайлан гаргах загварыг хоёрдугаар, дотоод хяналт шалгалтын ажлын үр дүнг үнэлэх хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

2.Журмын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, харьяа аж ахуйн нэгж, байгууллагын дарга (захирагч) нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлах тухай” А/294 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан)-т даалгасугай.

САЙД



Д.БАТЛУТ

1325100883

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн
А/502 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбар, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “нэгтгэл, анги, байгууллага” гэх)-ын дотоод хяналт шалгалттай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалт (цаашид “Хяналт шалгалт” гэх)-ыг зохион байгуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий албан тушаалтны баталсан хэм хэмжээний актууд, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. Хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, эрсдэлд суурилсан нэгдмэл төлөвлөлт, зохион байгуулалттай, хөндлөнгийн аливаа нөлөөлөл болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчимд тулгуурлана.

1.4. Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч (БХЕХШ), Батлан хамгаалах яамны Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын нэгж (ХШҮДАН), Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (ХШҮГ) (цаашид “хяналт шалгалтын нэгжүүд” гэх) Монгол Улсын хууль, тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, эрх бүхий байгууллагын нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон хэм хэмжээний актууд, энэхүү журмаар тогтоосон чиглэл, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

1.5. Дотоод хяналт шалгалтын нэгжгүй нэгтгэл, анги, байгууллага нь захирагч (дарга)-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй байж, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын удирдлага, зохион байгуулалт

2.1. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрийн нарийн бичгийн дарга, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (захирагч) нар Батлан хамгаалахын сайдын өмнө дотоод хяналт шалгалтыг хариуцан үр дүнг тайлагнана.

2.2. Төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги (салбар), байгууллагын дарга (захирагч) нар Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын өмнө дотоод хяналт шалгалтыг хариуцан үр дүнг тайлагнана.

2.3. Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч нь яамны болон Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангаж, дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

2.4.Нэгтгэл, анги, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хяналт шалгалтын нэгж болон орон тооны бус ажлын хэсэгтэй байна. Орон тооны бус байнгын ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухайн ажлын чиглэл, хамрах хүрээг харгалзан холбогдох мэргэжлийн албан тушаалтныг оролцуулж болно.

2.5.Дотоод хяналт шалгалтын нэгж, ажлын хэсэг нь байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан нэгтгэл, анги, байгууллагын даргаар батлуулна.

2.6.Хяналт шалгалтын нэгж, ажлын хэсэг нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд явуулна. Удирдамжийг тухайн хяналт шалгалтыг удирдан зохион байгуулах нэгж, ажлын хэсгийн дарга боловсруулж, нэгтгэл, анги, байгууллагын дарга батална.

2.7. Хяналт шалгалтын нэгж, ажлын хэсэг нь шалгалтад хамрагдсан нэгтгэл, анги, байгууллагад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, үр дүнг тооцно.

2.8. Нэгтгэл, анги, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцсэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Эрсдэлийн удирдлагын бодлого, үнэлгээ", "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.

2.9.Удирдлагын шийдвэрээр байгууллагуудын дотоод хяналт шалгалтын гүйцэтгэлд хийсэн хяналт, шалгалтын дүнг шаардлагатай тохиолдолд Батлан хамгаалахын дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

2.10.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд Үндэсний аудитын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар болон холбогдох салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бусад байгууллагаас дэмжлэг авч болно.

2.11.Энэ журмын 2.1, 2.2-т заагдсан албан тушаалтнууд нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Гурав. Дотоод хяналт шалгалтын чиглэлүүд

3.1. Дотоод хяналт шалгалт нь дараах чиглэлтэй байна:

3.1.1.Батлан хамгаалах салбарт Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцүүлэн хуулиар олгогдсон эрх бүхий албан тушаалтан, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан эрх зүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалт;

3.1.2.Санхүү, төсвийн үйл ажиллагаа, төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний чанар, худалдан авах ажиллагаанд хийх хяналт шалгалт;

3.1.3.Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, цэргийн албаны зохион байгуулалт, сургалт бэлтгэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон бусад мэргэжлийн хяналтын чиглэлээр хийх хяналт, шалгалт.

Дөрөв. Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч, түүний ажлын алба

4.1.Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын алба нь энэхүү журмын 3-т заасан чиглэлийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1. Журмын 3.1.1-д заасан чиглэлийн хүрээнд:

4.1.1.1. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх, Батлан хамгаалахын сайдыг бодит мэдээллээр хангах, хяналт шалгалтын дүнд үндэслэн арга хэмжээний санал боловсруулах, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх;

4.1.1.2. Батлан хамгаалах салбарт Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцүүлэн хуулиар олгогдсон эрх бүхий албан тушаалтан, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрийн нарийн бичгийн даргын баталсан эрх зүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмжөөр хангах;

4.1.1.3. Батлан хамгаалах салбарын хяналт шалгалтын нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, тэдгээрийн хяналт шалгалтын ажлын тайлантай танилцах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

4.1.1.5.Хяналт шалгалтын нэгжүүдийн дараа онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг нэгтгэн, “Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Батлан хамгаалахын сайдаар батлуулах.

4.1.2. Журмын 3.1.2-т заасан чиглэлийн хүрээнд:

4.1.2.1.Гадаад, дотоодын зээл, хандив, тусламжаар нийлүүлсэн зэвсэглэл, цэргийн технологи, техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.1.2.2.Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон тусгай хэрэгцээний газар, барилга, байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;

4.1.2.3.Улсын агаарын хөлөг, нисэх хэрэгсэл, улсын нисэхийн аэродромын бэлэн байдал, инженер, техникийн бүрэлдэхүүний сургалт, дадлагад хяналт тавих, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

4.1.3. Журмын 3.1.3-т заасан чиглэлийн хүрээнд:

4.1.3.1.Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын байдалд хяналт тавих, ашиг сонирхлын зөрчил болон үүсэж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах;

4.1.3.2.Цэргийн албанд хууль ёс, хүний эрхийн зарчмын хэрэгжилтийг хангаж буй байдлыг шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх;

4.1.3.3. Гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг шинжлэн судлах, дүн шинжилгээ хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;

Тав. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж

5.1 Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж нь энэхүү журмын 3-т заасан чиглэлийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1 Журмын 3.1.1-д заасан чиглэлийн хүрээнд:

5.1.1.1. Нэгтгэл, анги, байгууллагад Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцүүлэн хуулиар олгогдсон эрх бүхий албан тушаалтны болон Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрийн нарийн бичгийн даргын баталсан эрх зүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, удирдлагыг бодит мэдээллээр хангах;

5.1.1.2. Тодорхой чиг үүрэг бүхий ажлын хэсэг /орон сууц хуваарилах, сонгон шалгаруулах, ойн арга хэмжээ зохион байгуулах гэх мэтчилэн/-ийн үйл ажиллагаа, шийдвэр гаргасан байдалд хяналт шалгалт хийх;

5.1.1.3. Нэгтгэл, анги, байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж, ажлын хэсгийн үйл ажиллагаа, үр дүнд хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

5.1.2 Журмын 3.1.2-т заасан чиглэлийн хүрээнд:

5.1.2.1. Санхүү, төсвийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтад;

5.1.2.2. Төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд;

5.1.2.3. Зэвсэгт хүчний материал хэрэгслийн хангалт, батлан хамгаалах материаллаг нөөцийн бүрдүүлэлт, ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд;

5.1.2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд;

5.1.2.5. Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт, ашиг, орлого, санхүүгийн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд;

5.1.2.6. Батлан хамгаалах салбарт хэрэгжүүлж буй, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтэд;

5.1.2.7. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж олох орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, зарцуулалт, ашгийн байдалд;

5.1.2.8.Олон улсын болон хоёр талын хамтарсан сургалт, дадлагын санхүүжилт, төлбөрийн орлого, зарцуулалтын байдалд;

5.1.2.9. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад;

5.1.2.10.Гадаад, дотоодын зээл, хандив, тусламжийн орлого, зарцуулалт, нийлүүлсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд тус тус хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах;

5.1.2.11.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өмч хөрөнгө, санхүү төсвийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, үндэслэл бүхий мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах;

5.1.2.12.Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар үнэлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, удирдлагаар хангах.

Зургаа. Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар

6.1.Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар нь энэхүү журмын 3-т заасан чиглэлийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.1.1 Журмын 3.1.1-д заасан чиглэлийн хүрээнд:

6.1.1.1.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөр, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд;

6.1.1.2.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилогдсон тодорхой чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаанд;

6.1.1.3.Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

6.1.1.4.Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх.

6.1.2 Журмын 3.1.2.-д заасан чиглэлийн хүрээнд:

6.1.2.1.Төсвийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, үр ашиг, төрийн өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, байдал, худалдан авах ажиллагаанд;

6.1.2.2.Цэргийн бүх төрлийн материал хэрэгслийн хангалт, табель хэрэгсэл, авто хуягт, тусгай тоноглолтой техник, агаарын цэргийн техник хэрэгслийн ашиглалт, хадгалалт, зарцуулалт, хугацаа, нормын мөрдөлт, эд хөрөнгийн тооллого, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад;

6.1.2.3.Зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдал, галт хэрэглэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад;

6.1.2.4.Тавиулангийн албаны үйл ажиллагаа, үндсэн элементүүдийн үүрэг гүйцэтгэх боломж, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнд тус тус мэргэжлийн хяналт шалгалт хийх, шалган туслах.

6.1.3 Журмын 3.1.3-д заасан чиглэлийн хүрээнд:

6.1.3.1.Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлт, явц, үр дүн, сэтгэл зүйн хангалтын байдал, хүний нөөцийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд;

6.1.3.2.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын цэргийн албаны зохион байгуулалт, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд;

6.1.3.3.Тусгай тоноглолтой техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, өндөр даралтын сав, хэрэглэл, өргөх механизм, өргөх хэрэгслийн чанар байдал, баталгаажилт, аюулгүй ажиллагаанд;

6.1.3.4. Харилцаа холбоо, цахим систем, сүлжээ, өгөгдлийн хамгаалалт, кибер аюулгүй байдлын зохион байгуулалт, эрхийн хяналт, мэдээллийн урсгал, нууц хадгалалт, хамгаалалт, архив, баримт бичгийн хөтлөлт бүрдүүлэлт;

6.1.3.5.Хэмжил зүй, хөдөлмөр, барилга техник, цахилгаан эрчим хүч, гал түймрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хүнс, ундны ус, орчны аюулгүй байдал, халдвар хамгаалал, мал, амьтан, хорио цээрийн чиглэлээр тус тус мэргэжлийн хяналт шалгалт хийх, шалган туслах.

Долоо. Анги, байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж,
орон тооны бус ажлын хэсэг

7.1. Нэгтгэл, анги, байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж, орон тооны бус ажлын хэсэг нь энэхүү журмын 3-т заасан чиглэлийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.1.1. Журмын 3.1.1-д заасан чиглэлийн хүрээнд:

7.1.1.1. Нэгтгэл, анги, байгууллагад хууль тогтоомж, тушаал, шийдвэр, үүрэг, даалгаврын хэрэгжилтийн байдалд хяналт тавих;

7.1.1.2.Шилэн дансны тухай хууль, холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд сар бүр тогтмол хяналт тавих;

7.1.1.3."Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын хэрэгжилт, албан тушаалтнуудын төрийн өмч, эд хөрөнгийн хариуцлагатай холбоотой үүргийн биелэлтийг сар бүр шалгах, хяналт тавих;

7.1.2. Журмын 3.1.2.-д заасан чиглэлийн хүрээнд:

7.1.2.1.Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад;

7.1.2.2.Өмч хөрөнгийн ашиглалт, арчлан хамгаалалт, хадгалалтад;

7.1.2.3.Цэргийн алба хаагчийн ахуй хангалт, төвлөрсөн болон төвлөрсөн бус хангалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн бараа материалын чанар байдал, зарцуулалт, нормын мөрдөлтөд;

7.1.2.4.Үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, байдалд;

7.1.2.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд тус тус хяналт, шалгалт хийх;

7.1.2.6.Эд хөрөнгийн тооллогыг бодитой, үнэн зөв хийж буй эсэхэд хяналт тавих, гэнэтийн болон хэсэгчилсэн тооллого сар бүр тогтмол явуулах;

7.1.2.7.Бие бүрэлдэхүүний цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын тооцоолол, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгал, төлөлтөд хяналт тавьж, цалингийн цэсийг банкны болон бусад холбогдох баримттай тулган баталгаажуулах ажлыг улиралд 1-ээс доошгүй удаа хийх;

7.1.3. Журмын 3.1.3-д заасан чиглэлийн хүрээнд:

7.1.3.1. Холбоо, мэдээллийн аюулгүй байдал, архив, албан хэрэг хөтлөлт, албаны нууцын горим, барилга техник, эрчим хүч, гал түймэр, хүнс, орчны аюулгүй байдал, халдвар хамгаалал, мал, амьтан, хорио цээрийн хяналтын тухай холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэд;

7.1.3.2.Цэргийн сургалт бэлтгэл, мэдээлэл, сурталчилгаа, сэтгэл зүйн хангалтын байдал, соёл хүмүүжлийн ажил, ажлын байрны нөхцөл байдалд;

7.1.3.3.Цэргийн алба хаагчийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, хүний эрхийг хангах талаар гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд;

7.1.3.4.Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангасан байдалд тус тус хяналт, шалгалт хийх;

7.1.3.5. Цэргийн нэгтгэл, анги, салбарын эрүүл мэндийн төвийн үзүүлж буй тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, эмнэл зүйн удирдамж, заавар, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн чадавх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, хангамжид хяналт шалгалт хийх;

7.1.3.6. Боловсролын байгууллага нь сургалтын хөтөлбөр, чанарт хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх.

7.2. ХШҮДАН яамны харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, ХШҮГ Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбарын дотоод хяналт шалгалтын ажлын үр дүнг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлт тус бүрээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа явцыг 0-100 оноогоор үнэлэн нийт хэрэгжилтийг дараах байдлаар дүгнэнэ.

Нийт хэрэгжилтийн дүн= хэрэгжсэн ажлын нийт оноо/хэрэгжүүлбэл зохих ажлын нийт оноо*100

7.2.1. Хэрэгжилт 85 хувь буюу түүнээс дээш бол "маш сайн;

7.2.2. Хэрэгжилт 65-84 хувь бол "хангалттай";

7.2.3. Хэрэгжилт 0-64 хувь бол "хангалтгүй" гэж дүгнэж, тухайн анги, байгууллагын удирдлагад танилцуулна.

7.3. Нэгтгэл, анги, байгууллагын дотоод хяналтын орон тооны нэгж нь энэхүү журмын 7.1-д зааснаас гадна өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бусад хяналт шалгалтыг явуулж болно.

7.4. Нэгтгэл, анги, байгууллагын дотоод хяналтын орон тооны бус ажлын хэсэг нь энэхүү журмын 7.1-д заасан хяналт шалгалтыг явуулахад өөрийн хүний нөөцийн мэдлэг, ур чадвараас давсан асуудлыг холбогдох мэргэжлийн албан тушаалтан, байгууллагаар шалгуулах саналаа Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжид албан бичгээр гаргана.

7.5. Дотоод хяналтын нэгж, ажлын хэсэг нь хяналт шалгалтын ажлын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримтыг хавсаргана.

7.5.1. Дотоод хяналт шалгалтын орон тооны бус комисс томилсон тушаал;

7.5.2. Хяналт шалгалтын ажлын жилийн төлөвлөгөө;

7.5.3. Хяналт шалгалтын ажлын удирдамж;

7.5.4. Хяналт шалгалт хийсэн нотломж, тэмдэглэл;

7.5.5. Нэгтгэл, анги, байгууллагын дарга, захирагчийн зөвлөлийн хурлаар хяналт шалгалтын дүнг хэлэлцүүлсэн тэмдэглэл, шийдвэр;

7.5.6. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;

7.5.7. Дотоод хяналт шалгалтын сар, улирал, жилийн тайлан.

7.6. Дотоод хяналт шалгалтын ажлын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална.

Найм. Дотоод хяналт шалгалтын нэгж, албан тушаалтны
нийтлэг эрх, үүрэг

8.1. Нэгтгэл, анги, байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын ажилд шаардлагатай тайлан, мэдээ, танилцуулга, судалгаа, лавлагаа болон холбогдох бусад баримт, материалыг гаргуулан авах, холбогдох албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонсох;

8.2. Албан ажлын шугамаар архивын болон нууц материалтай эрх бүхий байгууллагаас олгосон нууцын эрхийн хүрээнд танилцах, хяналт шалгалт хийх об'ектод саадгүй нэвтрэх;

8.3. Хяналт шалгалтын явцад шаардлагатай гэж үзвэл төрийн өмч хөрөнгөд хяналтын тооллого хийлгэх;

8.4. Хяналт шалгалтын дүнд үндэслэн улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлт үйлдэхдээ Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулж, шалгуулагч байгууллага, албан тушаалтныг тайлбар, санал гаргах боломжоор хангана. Сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэл, тайлбар, саналыг баримтжуулж шалгалтын тэмдэглэлд хавсаргана.

8.5.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулах;

8.6.Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалах, албан ажлын шугамаар олж авсан мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах;

8.7.Эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

8.8.Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

8.9.Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар дээд шатны байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

8.10.Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг сурталчлах, хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

8.11.Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, гэмт хэргийн шинжтэй зөрчил дутагдлыг хуулийн байгууллагад шилжүүлэх санал боловсруулан удирдлагад танилцуулах;

8.12.Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах;

8.13.Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

8.14.Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн болон хүнсний аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг нэн даруй авч, удирдлагад мэдэгдэх;

8.15.Дотоод хяналт шалгалтаар бараа, бүтээгдэхүүний чанар стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд бүтээгдэхүүний дээж, сорьцыг авч, Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори болон итгэмжлэгдсэн бусад лабораторид шинжлүүлэх, дүгнэлт гаргуулах;

8.16.Албан тушаалтан нь энэхүү журамд заасан хяналт шалгалтыг явуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах, энэ тухай удирдах албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

Ес. Хяналт шалгалтын ажлыг тайлагнах

9.1.Дотоод хяналт шалгалтын ажлыг батлагдсан маягтын дагуу дараах хугацаанд тайлагнана.

9.1.1.Дотоод хяналт шалгалтын улирлын ажлын тайланг яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагууд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжид, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор;

9.1.2. Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар дотоод хяналт шалгалтын улирлын нэгтгэсэн тайланг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжид дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор;

9.1.3.Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж салбарын дотоод хяналт шалгалтын эхний хагас жилийн болон жилийн эцсийн нэгтгэсэн тайланг, Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар Зэвсэгт хүчний дотоод хяналт шалгалтын эхний хагас жилийн болон жилийн эцсийн нэгтгэсэн тайланг тус тус боловсруулж, Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид 07 дугаар сарын 25, дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

Арав. Бусад зүйл

10.1.Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг өөрийн анги, байгууллагын төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

10.2.Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж, Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар нэгтгэл, анги, байгууллагын орон тооны бус ажлын хэсгээс гаргасан албан даалгавар, шаардлага, акт, зөвлөмжийг байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх, тогтоосон хугацаанд хариу мэдэгдэх үүрэгтэй.

10.3. Дотоод хяналтын нэгж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

10.4.Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарсан гомдлыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу салбарын хяналтын чиг үүрэг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад шалгалтын дүн, акт, албан шаардлагын талаар мэдэгдэж гарын үсэг зуруулснаас хойш 30 хоногийн дотор гаргаж шийдвэрлүүлнэ.

10.5. Яамны ХШҮДАН, ЗХ-ний ХШҮГ нь нэгтгэл, анги, байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын үр дүнд хийсэн үнэлгээг үндэслэн маш сайн болон хангалтгүй үнэлэгдсэн ажлын хэсэг, нэгжийг урамшуулах, сахилгын хариуцлага тооцох саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

10.6. Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүний хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгуулан, үр дүнг тооцох, Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг дүгнэхэд харгалзан үзнэ.

10.7.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
 12- дугаар сарын 25-ны өдрийн
 1/507- дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нэг. ... ДУГААР АНГИ /БАЙГУУЛЛАГА/-ЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН
 ХЭСГИЙН САР /УЛИРАЛ/-ЫН ТАЙЛАН

Д/д	Шалгасан чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга, үндэслэл	Зөрчлийн мөнгөн дүн /мян.төг/	Шалгасан байгууллага /ажлын хэсэг/- аас гаргасан шийдвэр	Алдаа зөрчил гаргасан болон хариуцах албан тушаалтны		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
					Албан тушаал	цол, овог нэр	

Баталгаажуулсан: /албан тушаал, нэр/
 /гарын үсэг, тамга, тэмдэг/

Хянаж хүлээн авсан:

Тайлан гаргасан: /албан тушаал, нэр/

Хоёр. ... ДУГААР АНГИ /БАЙГУУЛЛАГА/-ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖИЙН
 УЛИРАЛ /ХАГАС ЖИЛ, ЖИЛ ЖИЛИЙН ЭЦСИЙН/-ЫН ТАЙЛАН

Д/д	Анги, байгууллагын нэр	Шалгасан чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга, үндэслэл	Зөрчлийн мөнгөн дүн /мян.төг/	Шалгасан байгууллагаас гаргасан шийдвэр	Алдаа зөрчил гаргасан болон хариуцах албан тушаалтны		Дүгнэлт	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санал, зөвлөмж
						Албан тушаал	цол, овог нэр		

Жич: Тайланг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэж, өссөн дүн, мэдээллээр гаргана.

Баталгаажуулсан: /албан тушаал, нэр/
 /гарын үсэг, тамга, тэмдэг/

Тайлан гаргасан: /албан тушаал, нэр/

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
12 дугаар сарын 16-ны өдрийн
1/502 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ХУУДАС

	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Нэгтгэл, анги, байгууллагад хууль тогтоомж, тушаал, шийдвэр, үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн эсэх	
2	Шилэн дансны тухай хууль, холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн эсэх (сар бүр)	
3	Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын хэрэгжилт, албан тушаалтнуудын төрийн өмч, эд хөрөнгийн хариуцлагатай холбоотой үүргийн биелэлтэд хяналт шалгалт хийсэн эсэх (сар бүр)	
4	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийсэн эсэх	
5	Өмч хөрөнгийн ашиглалт, арчлан хамгаалалт, хадгалалтад хяналт шалгалт хийсэн эсэх	
6	Цэргийн алба хаагчдын ахуй хангалт, төвлөрсөн болон төвлөрсөн бус хангалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн бараа материалын чанар байдал, зарцуулалт, нормын мөрдөлтөд хяналт шалгалт хийсэн эсэх	
7	Үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар байдалд хяналт шалгалт хийсэн эсэх	
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийсэн эсэх	
9	Эд хөрөнгийн тооллогыг бодитой, үнэн зөв хийж буй эсэхэд хяналт тавих, гэнэтийн болон хэсэгчилсэн тооллого тогтмол явуулсан эсэх (сар бүр)	
10	Бие бүрэлдэхүүний цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын тооцоолол, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгал, төлөлтөд хяналт тавьж, цалингийн цэсийг банкны болон холбогдох баримттай тулган баталгаажуулсан эсэх (улиралд 1-ээс доошгүй удаа)	
11	Холбоо, мэдээллийн аюулгүй байдал, архив, албан хэрэг хөтлөлт, албаны нууцын горим, барилга техник, эрчим хүч, гал түймэр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хөдөлмөр, хүнс, орчны аюулгүй байдал, халдвар хамгаалал, мал амьтан, хорио цээрийн хяналтын тухай холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн эсэх	
12	Цэргийн сургалт бэлтгэл, мэдээлэл, сурталчилгаа, сэтгэл зүйн хангалтын байдал, соёл хүмүүжлийн ажил, ажлын байрны нөхцөлд хяналт шалгалт хийсэн эсэх	
13	Цэргийн алба хаагчийн хүний эрхийг хангах, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилгын хариуцлагыг бэхжүүлэх талаар гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн эсэх	
14	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангасан байдалд хяналт шалгалт хийсэн эсэх	
15	Аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогтой нийцсэн хяналт шалгалт хийсэн эсэх	

16	Дотоод хяналт шалгалтын тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн эсэх	
17	Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүний хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгуулан, үр дүнг тооцож, Төрийн алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэхэд харгалзаж үзсэн эсэх	
Оноо		
Үнэлгээ		
Танилцсан албан тушаалтны гарын үсэг		

Хэрэгжилтийн хувиар 0-100 оноогоор үнэлнэ.